ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 06 дугаар сарын 10 Залаа

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **1. Төрийн захиргаа, удирдлага зохион байгуулалт, төрийн албаны тухай хуулийн болон бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд** | | | | | | | |
| 1.1 | Сумын ЗДТГ-ын 2025 онд ажиллах бүтэц орон тоо цалингийн санг шинэчлэн тогтоож, төрийн үйлчилгээний болон улс төрийн албанд шинээр орсон албан хаагчдын гэрээг шинэчлэн батлах | - | Батлагдсан бүтэц орон тоо, шинээр байгуулсан гэрээ | 80% | 100% | 01 дүгээр сард бүтэц орон тоог 23 албан хаагчтайгаар баталж, Бүх албан хаагчдын гэрээг шинээр батлан ажилласан | 100% |
| 1.2 | Төрийн албан хаагчийн сургалт ажиллах нөхцөл, нийгмийн баталгаах хангах төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг хանган ажиллах | - | Төлөвлөгөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах | 0% | 100% | Төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа бөгөөд. Хагас жилийн байдлаар нийт 35 албан хаагчийг Нура төвд урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, 2-3 албан хаагчдад хэрэгтэй нөтбүүк, принтерээр хангаж ажилласан. Мөн ар гэрт нь хүнд асуудал үүссэн албан хаагчдад мөнгөн тусламж болон 30 хүртэлх хоногийн чөлөө олгож ажиллаж байна. | 100% |
| 1.3 | Сумын түүхт 70 жилийн ойг угтан бүтээн байгуулалт, үйл ажиллагааг зохион байгуулах | Боломжит эх | 1-2 бүтээн байгуулалт, үйл ажиллагааг | 0 | 100% | Сумын түүхт 70 жилийн ойг угтан Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Гудамж талбайн өнгө үзэмжийг сайжруулах ажлын | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | үүсвэр | зохион байгуулах | | | тендер зарлаж гүйцэтгэгчээр шалгарсан байгууллагатай гэрээ байгуулсан. Мөн спорт цэцэрлэгт хүрээлэнгийн орчимд Нийтийн бие засах газар байгуулах тендер зарлаж гүйцэтгэгчээр “” ХХК шалгарсан. | |
| 1.4 | Малчид, төлчидийн зөвлөгөөнийг зохион байгууллах | Засаг даргын нөөц хөрөнгө | Хамрагдсан малчидын тоо | 0% | 100% | Малчид төлчдийн зөвлөгөөнийг 2025 оны 02 дугаар сарын 5, 6-ны өдрүүдэд Засаг даргын 08 дугаар захирамжийн дагуу ажлын хэсэг томилогдон зохион байгууллаа. Зөвлөгөөнд аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан бүрэлдэхүүнийг хамт, аймгийн ИТХ-ын төлөөлөгч Л.Чинзориг нар оролцож, төр засаг, аймаг орон нутгийн бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хэтийн хөгжлийн талаар бодит мэдээллээр хангалаа. Шинэжинст сум луу жилд 14 сумын аварга малчин өрх, аварга саальчин хоёр, аварга тариаланч нэгийг тодруулж, төл малаа хорогдолгүй бойжуулсан малчдаа алдаршуулсны зэрэгцээ сум орон нутгийнхаа нэрийг улсад гаргасан шатар сонирхогчдын улсын аварга И.Нангилмаа, Монгол улсын харишгүй мэргэн цол хүртсэн М.Доржбат, оны онцлох хүүхэд Т.Баясгалан нарын эрхмүүдээ сумын хүндэт дэвтэрт нэрийг мөнхлөн хүндэтгэл илэрхийлэв. Нийт 616 малчин өрх, 186.5 мянган толгой малтай, луу жилд Улсын алдарт уяачаар С.Бямбасүрэн нар тодорсон байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.5 | Нутгийн зөвлөлийн нийтийн золгуудыг зохион байгууллах | Засаг даргын нөөц хөрөнгө | Хамрагдсан иргэдийн тоо | - | 100% | Баянхонгор аймгийн нутгийн зөвлөлийн золголтын арга хэмжээ аймгийн төвд 2025 оны 03 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулагдаж 9 албан хаагч оролцож зохион байгуулалт, үйлчилгээний ажлыг хариуцан ажилласан. Тус золголтын арга хэмжээнд нутгийн зөвлөлийн 52 иргэд оролцсон бөгөөд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын | 100% |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | төлөөлөгч Л.Чинзориг, сумын удирдлагууд оролцож нутаг орны хөгжил, дэвшил, ирэх онд болох сум байгуулагдсаны 70 жилийн ой угтсан ажлын талаар санал солилцлоо. Улаанбаатар хот дахь Баянхонгор аймгийн нутгийн зөвлөлийн золголт 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр Бөхийн өргөөнд зохион байгуулагдаж тус арга хэмжээнд албан хаагчид өргөн бүрэлдэхүүнээр оролцсон. Улс аймгийн цолтой 128 бөхийн барилдаан болж Ламын гэгээнтэн айлдвар айлдаж нутаг усныхан золголдон учирсан арга хэмжээ болсон. Мөн өдрийн 17 цагт Улаанбаатар хот дахь нутгийн золголтын арга хэмжээ болсон. Тус арга хэмжээнд нутгийн 100 гаруй иргэд оролцсон бөгөөд сумын удирдлагууд болон АИТХ-ын төлөөлөгч нар сум орон нутгийн хөгжил, дэвшил, тулгамдаж буй асуудлууд болон ирэх онд болон сум байгуулагдсаны 70 жилийн ойн арга хэмжээний талаар санал бодлоо солилцлоо. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.6 | Байгууллагын албан хаагчдын урьдчилан сэргийлэх үзлэг болон спортоор хийчээллэх үйл ажиллагааг зохион байгуулж | Боломжит эх үүсвэр | Хамрагдсан албан хаагчдын тоо | 0% | 100% | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, дотоод журамд заасны дагуу нийт албан хаагчдаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар Улаанбаатар хот дахь эрт илрүүлгийн Нура төвтэй гэрээ байгуулан 2025 оны 03 дугаар сарын 11,12-ны өдрүүдэд нийт 39 албан хаагчийг бүрэн хамрууллаа. Үүнээс өөрийн биеэр очиж үзүүлсэн 31, бэлгийн картаар буюу ондоо багтааж үзүүлэх 6 албан хаагч байсан. Нура эрт илрүүлэгийн төв нь хиймэл оюун ухаанд суурилсан Монгол дахь цорын ганц төв бөгөөд тус төвөөр үйлчлүүлсэн албан хаагчид тус бүр 36 төрлийн багц шинжилгээнд орж, шинжилгээний нэгдсэн дүгнэлтээр эмчийн зөвлөгөө авсан байна. Мөн албан хаагчдыг долоо хоног бүрийн 4 дэхь өдөр болгон зааланд | 100% |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | спортоор хичээллэх цагийг олгон ажиллаж байна. | |
| 1.7 | Аймгийн 20 сумдыг хүлээн авч урлаг, спортын бага наадмыг зохион байгуулах | Боломжит эх үүсвэр | Хамрагдсан сумын тоо | 0% | 100% | III дугаар улиралд хийгдэхээр төлөвлөн ажиллаж байна. | 30% |
| **2. Хууль, эрх зүйн боловсролыг дээшлүүлж, бодолгын баримт бичиг, холбогдох хууль, тогтоомжийг хангах, бүх нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд:** | | | | | | | |
| 2.1 | Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлж аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу үр дүнтэй тайлагнах | - | Тайлангийн ирц<br>Тайлангийн чанар БББ, ХТТШ-ийн хэрэгжилтийн хувь | 0% | +50%<br>100% | Хагас жилийн байдлаар Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг цаг хугацаанд нь 76.2%-тайгаар хэрэгжүүлэн тайлагнан ажилласан байна. | 75% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2 | Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны ёс зүй тухай хуулийн талаар сургалт зохион байгуулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх | - | Ёс зүйн зөрчил, гэмт хэрэгт холбогдсон албан хаагчийн тоо | - | 100% | Хагас жилийн байдлаар Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй. | 100% |
| | | - | Төрийн алба тухай болон Төрийн албаны ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах | - | 100% | Хагас жилийн байдлаар нийт 4 удаагийн сургалтыг нийт төрийн албан хаагчдын дунд болон дотоодод зохион байгууллаа. Сургалтад давхардсан тоогоор 200 албан хаагч хамрагдлаа. | 100% |
| 2.3 | Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд болон цахим хуудсанд нээлттэй | - | Шинэчилсэн мэдээ, үйлчилгээний тоо, хэрэгжилт | 50<br>70% | +70%<br>100% | Төрийн үйлчилгээний оператор ажлын байранд 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн Г.Батчимэгийг томилж, цахимын ил тод байдлыг хариуцуулж ажиллаж байна. | 100% |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | байршуулж, хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах | | | | | Байгууллагын Ил тод байдлыг сайжруулж, сумын сайт дээр ил тод байхаар заагдсан 98 төрлийн мэдээг байршуулж байна. Мөн цахим сайтад цаг үеийн 8 мэдээ байршуулсан байна. Шинэжинст сум мэдээ мэдээллийн албан ёсны хуудаст нийт **103** мэдээ оруулсан байна. Үүнээс хөтөлбөрт үйл ажиллагааны зар 19, тайлан мэдээ 13-г оруулсан байна. Мөн видео мэдээ 7, цаг үеийн 38 мэдээ, орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн ажлын 3 мэдээ, засаг даргын тамгын газрын төсөвт хөрөнгөөс зарцуулсан ажлын 1 мэдээ, Зарын чанартай 18 мэдээ, Мэндчилгээ 2, Уриалга 3 тус тус байршуулан ажиллаж байна. | |
| 2.4 | “Хуулиа дээдэлье” аяныг сум орон нутгийн хэмжээнд чанартай, үр дүнтэй зохион байгуулах | | Төлөвлөгөөний хэрэгжилт | 0% | 100% | Аяны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хагас жилийн байдлаар 50%-тайгаар хангаж ажилласан байна. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.5 | “Авлигтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг сум орон нутгийн хэмжээнд чанартай, үр дүнтэй зохион байгуулах | - | Төлөвлөгөөний хэрэгжилт | 0% | 100% | Төлөвлөгөөг 02 дугаар сард батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд сургалт мэдээллэл орж , гарын авлага тараан ажилласан бөгөөд Авилгын гэмт хэрэг, зөрчил, гомдол мэдээлэл ирээгүй ажиллаж байна. | 50% |
| 2.6 | Irgen.bayanhongor.gov.mn иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны нэгдсэн системийн ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлж, иргэдийн судалгаанд хамруулах, өргөдөл гомдлыг бүртгэх, шийдвэрлүүлэх | - | Судалгаанд хамруулсан иргэдийн тоо, бүртгэсэн, шийдвэрлүүлсэн өргөдөл гомдол, хүсэлийн тоо | 0% | 150-с дээш | Сэтгэл ханамжийн судалгаанд 100 гаруй иргэнийг хамруулсан байна. | 50% |
| 2.7 | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлж шинээр батлагдаж буй хуулийн төсөлд санал авах, шинээр батлагдсан болон ард иргэдэд хэрэгцээтэй байгаа хуулиар сургалт мэдээллэл хийх, гарын авлага тараах | - | Бүх нийтэд хийсэн сургалт сурталчилгаа, хэлэлцүүлэг, тараасан гарын авлага<br>Төрийн албан хаагчдын дунд хийсэн сургалт сурталчилгаа, хэлэлцүүлэг, тараасан гарын авлага | 0% | 100% | Иргэдэд хэрэгцээтэй байгаа Малчны тухай хууль, Үндсэн хууль, гэр бүлийн тухай хуулиудаар нийт 200 гаруй иргэдэд сургалт орсон байна. | 50% |
| 2.8 | Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах | - | Хяналт шалгалтын тоо<br>Сургалтын тоо | 0% | 100% | 03 дугаар улирлаас хийгдэхээр хүлээгдэж байна | 0% |
| 2.9 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар | - | Нөлөөллийн арга хэмжээний | 0% | 2 | Тус хэрэгжилтийн хүрээнд сургалтыг багийн хурлаар зохион байгуулж 200 гаруй иргэд | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зүйлийн хэрэгжилтийг ханган ажиллах | | тоо | | | оролцсон мөн гарын авлагыг тараан ажилласан байна. | |
| 2.10 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангаж ажиллах | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 0% | 3 | 1 удаагийн сургалтыг зохион байгуулж ажиллалаа. | 30% |
| | | - | Энэ төрлийн гэмт хэргийн бууралтын хувь | Тухайн суманд үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн тоо | 0,5 хувиар бууруулах | Хагас жилийн байдлаар гэмт хэрэг зөрчил бүртгэгдээгүй байна Тус хуулиар Хууль, эрх зүйн мэргэжилтэн 1 удаагийн сургалтыг 50 иргэдэд орсон. | 30% |
| 2.11 | Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, олон нийтийн авлигатай тэмцэх хүсэл зоригийг нэмэгдүүлэх санаачилга гарган Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хангаж, үр дүнд хүргэж ажиллах | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 90% | 100% | Төлөвлөгөөг батлуулан Авлигтай тэмцэх газрын 110 утасыг сурталч, гарын авлага тараан, сургалтын үеэр мэдээлэл хүргэн хэрэгжилтийг хanган ажиллаж байна. | 50% |
| 2.12 | Цахим хуудасны ил тод байдлыг сайжруулахад анхаарч мэдээллүүдийг бүрэн байршуулж, шинэчлэн ажиллах | - | Ил тод байдлын үнэлгээний хувь | 0% | Өмнөх оны жилийн эцсийн үнэлгээг 20-с дээш хувиар нэмэгдүүлэх | Ил тод байдлыг сайжруулж, сумын сайт дээр ил тод байхаар заагдсан 98 төрлийн мэдээг байршуулж байна. Мөн цахим сайтад цаг үеийн 8 мэдээ байршуулсан байна. Шинэжинст сум мэдээ мэдээллийн албан ёсны хуудаст нийт **103** мэдээ оруулсан байна. Үнээс хөтөлбөрт үйл ажиллагааны зар 19, тайлан мэдээ 13-г оруулсан байна. Мөн видео мэдээ 7, цаг үеийн 38 мэдээ, орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн ажлын 3 мэдээ, засаг даргын тамгын | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газрын төсөвт хөрөнгөөс зарцуулсан ажлын 1 мэдээ, Зарын чанартай 18 мэдээ, Мэндчилгээ 2, Уриалга 3 тус тус байршуулан ажиллаж байна. Үнэлгээ хийгдэх хугацаа болоогүй байна. | |
| 2.13 | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх тухай хуульд заасан хориглолт хязгаарлалтыг мөрдөж ажиллах | - | Зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээний тоо | - | 2 | Тус хуулийн хүрээнд Төрийн албан хаагчдын зөвлөгөөнийг 04 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулж Аймгийн Хууль, эрх зүйн хэлтэсийн дарга Д.Сарангаравыг урьж мөн хуулиар болон Авлигын эсрэг хуулиар сургалт орсон бөгөөд зөвлөгнөөс авлигаас ангид байх уриалга гарган ажилласан байна | 70% |
| 2.14 | Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх | - | Хүлээн авсан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэлт | 0% | 100% | Хагас жилийн байдлаар нийт 43 өргөдөл ирсэнийг тухай бүр холбогдох албан хаагч, байгууллагад хүргэн 39 өргөдөлийг хуульд заасан хугацаанд шийдвэрлэн ажилласан байна. Мөн мэдээ, тайланг хугацаандаа хүргүүлэн ажиллаж байна. | 90% |
| **3.Архив, албан хэрэг хөтлөлийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд:** | | | | | | | |
| 3.1 | “Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах 2023-2027 оны бодлого чиглэл”-ийг хэрэгжүүлэх | | Баримтын хадаглалт, хамгаалалт сайжрах | 70 хувь | 100% | Байгууллагын архивт 1994-2024 оны 70 жил болон түр хадгалах баримтыг зориулалтын нягтруулах шүүгээнд хадгаламжийн нэгж болгон хавтаслан хайрцаглаж хаяглан хадгалж байна. Хадгалалт хэвийн 6 нягтруулах шүүгээнд баримтыг 100 хувь байршуулсан. | 100% |
| 3.2 | “Цахим архив-Баянхонгор” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж байгууллагын 2022 оны баримтыг Төрийн архивд цаасан болон цахим хэлбэрээр дансны хамт бүрэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах | | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Засаг даргын Тамгын газрын 2022 оны байнга хадгалах 148 баримтыг цахим болон цаасан хэлбэрээр төрийн архивт хүлээлгэн өгөөд байна | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3 | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийг хэрэгжүүлэх, 2025 оноос Төрийн албан хэргийг Монгол бичгээр явуулах бэлтгэл ажлыг хангах, 03 дугаар сарын 01-ээс эхлэн захирамж, тушаал, албан бичгийг Монгол бичгээр хослуулан хөтлөх, хэвшүүлэх | - | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 70% | 90% | Энэ оны эхнээс захирамж, тушаал, Засаг даргын болон Тамгын газрын албан бичгийг монгол бичгээр хослуулан хөтөлж эхлээд байна. Хагас жилийн байдлаар захирамж 95, Засаг даргын албан бичиг 113, Тамгын газрын даргын албан бичиг 95 гаргасан байна. | 100% |
| 3.4 | Албан хаагчид 2024 оны баримтыг ХНЖагсаалтын дагуу бүрэн бүрдэлтэйгээр эхний улирлын 25-ны дотор багтаан байгууллагын архивт бүрэн хүлээлгэн өгөх | - | Хүлээн авсан баримтын тоо | 0% | 100% | Албан хаагчид 2024 онд хөтлөгдсөн баримтаа хадгаламжийн нэгж болгон нүүр, товьёо хийн хавтаслаж архивын ажилтан, баримт бичиг нягтлан шалгах комисст бүрдлийг шалгуулан байгууллагын архивт өгөхөд бэлэн болгоод байна | 50% |
| 3.5 | Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар 4 удаагийн сургалтыг зохион байгуулах | - | Албан хэрэг хөтлөлтийн стандартын зөрчилгүй болно | 0% | 100 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай байгууллагын албан хаагчдад 2 удаа сургалт хийж давхардсан тоогоор 51 албан хаагч хамрагдав. | 50% |
| 3.6 | 2025 Архивын улсын үзлэгт цаг хугацаанд нь бүрэн хамрагдах | - | Стандартын зөрчилгүй байх | 0% | 100% | Байгууллагын албан хаагчдад улсын үзлэгт баримтаа хэрхэн бэлтгэх хөтлөгдөж буй баримтын стандартын талаар байгууллагын хурал, цуглаан дээр 5 удаа зөвлөмж өгөх буюу ганцаарчилсан зөвлөмжийг тогтмол өгч байгууллагын дарга болон архив бичиг хэргийн ажилтан хяналт тавин ажиллаж байна. | 50% |
| 3.7 | ERP системийн ирсэн, явсан албан бичгийг хугацаанд нь хүлээн авч, танилцуулж, хааж хэвшиж | - | Ирсэн, хүлээн авсан, хаасан албан бичгийн тоо | 0% | 100% | Системээр ирсэн бичгийг өдөр тутамдаа хүлээн авч байгууллагын даргад танилцуулан холбогдох албан тушаалтанд бүртгэл үйлдэн шилжүүлж гарын үсгээр баталгаажуулан хүлээлгэн өгч байна. Хагас жилийн байдлаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 351 бичиг хүлээн авч шилжүүлсэн байна | |
| **5. Нийгмийн даатгал, татварын хүрээнд:** | | | | | | | |
| 5.1 | Малчин хувиараа хөдөлмөр эрхлэгч, оюутан залуусын эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах | - | Даатгалд хамрагдсан иргэдийн тоо<br>Хамралтын хувь | 90% | 100% | Тус сум нь 2025 оны жилийн эцсийн байдлаар Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд нийт 217 даатгуулагч хамруулсны 171 нь “Малчин” байгаа нь сайн дурын даатгалд хамрагдаж байгаа иргэдийн 79%-ийг эзэлж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт Сайн дурын 217 даатгуулагчидтай гэрээ хийсэн. Үүнээс шинээр нийт 26 иргэнтэй сайн дурын гэрээ байгууллаа, Гэрээнд заасны дагуу төлөх шимтгэлийг тооцон авч 217 даатгуулагч хамруулж 2025 оны 06 дугаар сарын 12-ны байдлаар 390,5257,100 төгрөгийн орлого оруулахаас 214,275,010 төгрөг хуримтлагдсанаар 54 хувиар биелүүлээд байна. Эхийн 0-3 настай хүүхэд ээ асрах чөлөөтэй хугацааны тэтгэмжийн сангаас төлөх шимтгэлд нийт 14 эхийг хамруулж жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөнд 7,475,510 төгрөгийн орлого оруулахаас 5452400 төгрөгийг хуримтлагдсанаар 72 хувиар биелүүлээд байна. Эхийн хүүхэд ээ асрах чөлөөтэй хугацааны улсын төсвөөс төлөх шимтгэлд нийт 13 эхийг хамруулж эхний хагас жилийн төлөвлөгөөнд 9,568,000 төгрөгийн орлого оруулахаас 7,464,600 төгрөгийг хуримтлагдсанаар 78 хувиар биелүүлээд байна.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эхийн шимтгэлд нийт 9 эхийг хамруулж эхний хагас жилийн төлөвлөгөөнд 6,761,500 төгрөгийн орлого оруулахаас 5,536,760 төгрөгийг хуримтлагдсанаар 79 хувиар биелүүлээд байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.2 | Нийгмийн даатгалын ач холбогдолыг олон нийтэд сурталчилан таниулах арга хэмжээг зохион байгуулах | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 | 3 | Нийгмийн даатгалын ач холбогдолыг нэмэгдүүлэх чиглэлээр 2025 оны эхний хагас жилийн байдлаар хамрагдалтыг нээлтэй хаалганы өдөрлөгийг 2 удаа зохион байгуулж давхардсан тоогоор нийт 43 иргэн ганцаарчилсан зөвлөгөө авлаа. Хуулийн сургалт сурталчилгааг 4 багийн хурлуудаар явж мэдээлэл өглөө давхардсан тоогоор нийт 431 иргэн хамрагдсан | 100% |
| 5.3 | Улс, орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг нэр төрөл тус бүрээр жигд ханган биелүүлэх | - | Өгөгдсөн орлогын төлөвлөгөөний хувь (Сар бүр жигд ажиллагааг ханган ажиллаж төлөвлөгөөний биелэлтийг ханган ажилласан байх) | 30% | 100% | Энэ онд үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараар 2275.8 сая.төг-ийн орлогын төлөвлөгөөтэй. Эхний улиралд 388549.2 мян.төг-ийн орлого төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн. Урьд оны өртэй 1 татвар төлөгчийн 241252 өрийн үлдэгдэл байгаа. Эрдэнэмонгол ХХК-ийн үл хөдлөхийн ногдлыг нэмэгдүүлэх, урьд оны өрийг барагдуулах талаар 2 удаа ажлын хэсгийн хамт очиж ажиллан зөвлөмж хүргүүлсэн. Эрдэнэмонгол ХХК үл хөдлөхийн хөрөнгийн бүртгэлээ шинэчилж бүртгүүлсэн тохиолдолд орлогын төлөвлөгөө биелэнэ. | 50% |
| 5.4 | Нийгмийн даатгалын болон Татварын хууль тогтоомжийн талаар сургалт, сурталчилгааг зохион байгууллах | - | Зохион байгуулсан сургалт, сурталчилгаа, хамрагдсан иргэдийн тоо | 0% | 100% | Нийгмийн даатгалын ач холбогдолыг нэмэгдүүлэх чиглэлээр 2025 оны эхний хагас жилийн байдлаар хамрагдалтыг нээлтэй хаалганы өдөрлөгийг 2 удаа зохион байгуулж давхардсан тоогоор нийт 43 иргэн ганцаарчилсан зөвлөгөө авлаа. Хуулийн сургалт сурталчилгааг 4 багийн хурлуудаар явж мэдээлэл өглөө давхардсан тоогоор нийт 431 иргэн хамрагдсан. ХХОАТ, Татварын цахимын шинэчлэлийн тухай, ААНОАТ-ын хуулийн шинэчлэлийн талаар танхимын болон ажлын байрны 5 удаагийн сургалтад 380 гаруй иргэн хамрагдсан байна. Гарын | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | авлагыг 90 гаруй өрхөд тараасан. Сургалтын бүртгэлийг маягтын дагуу бүртгэсэн. | |
| **6. Хүн амын хөгжил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:** | | | | | | | |
| 6.1 | Сум орон нутгийн байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийн гишүүдийг чадавхжуулах, тэднээр дамжуулан эцэг эхчүүдэд хүрч ажиллах, “Шилдэг эцэг эхийн зөвлөл” шалгаруулах арга хэмжээг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх | 1500. 000 | Чадавхжуулах арга хэмжээний тоо<br>Зөвлөлийн үйл ажиллагаанд хамрагдсан эцэг эхчүүдийн тоо<br>Шинээр байгуулагдсан эцэг эхчүүдийн тоо<br>Төрийн байгууллага \ аж ахуйн нэгж\<br>Уралдаанд оролцсон байгууллагын тоо | 2<br>289<br>5<br>5<br>5 | 6<br>800<br>6<br>6 | Аймгийн гэр бүл, нийгмийн салбарын ажлын хэсэг 05 дугаар сард Хамтаръя-Хэрэгжүүлэх өдөрлөгийг Шинэжинст сумад зохион байгуулан ажилласан бөгөөд тухайн үеэр эцэг эхийн зөвлөлийг дарга У.Мөнхнаран зөвлөгөө, мэдээллийг авч ажиллалаа. Эх, үрсийн баяраар байгууллагын 70 гаруй хүүхдүүдэд гарын бэлэг тараан ажилласан бөгөөд санхүүг Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдүүлэн ажилласан. Гэр бүлийн өдрөөр хөгжөөнт тэмцээнийг, мөн хүүхдийн баяраар эцэг, эхийн хүүхдүүдийн дунд хөгжөөнт тэмцээнийг зохион байгуулан ажиллалаа. | 70% |
| 6.2 | Суралцагч сум арга хэмжээг зохион байгуулах | 5.000. 000 | Төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангах | 0% | 100% | Тус арга хэмжээний хүрээнд Төлөвлөгөөг батлуулж. Гэр бүлийн өдрөөр 10 гэр бүлийн дунд хөгжөөнт тэмцээн, хуулийн сургалтыг зохион байгууллаа мөн хуулиа дээдэлье 1 хуулийн сорилтот 4 албан байгууллагыг оролцуулан амжилттай зохион байгуулж ажиллалаа. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.3 | Эрсдэлт нөхцөлд байгаа болон хараа хяналтгүй хүүхдийг илрүүлэх, мэдээллийн санд бүртгэх, хүүхэд түүний гэр бүлд чиглэсэн үйлчилгээг төлөвлөж, эргэн хяналтыг тогтмол хийж, хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих | - | Эрсдэлт нөхцөлд байгаа болон хараа хяналтгүй хүүхдийн тоо 85 | 100% | 100% | Сумын Засаг даргын Захирамжаар 03 дугаар сард Өрхийн айлчлалыг зохион байгуулж 04 ажлыг хэсэг томилогдон айл өрхүүдээр орж ажиллалаа. Эрдэнэшанд 03 дугаар баг, Зараа 1 дүгээр багт эрдэлд нөхцөл байдлыг ирүүлэн ажиллалаж 2 айлд гэр олгож, гэр ахуйн, хувцас хэрэглэлийн тусламж үзүүлэн ажиллалаа. | |
| 6.4 | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Хүүхдийн төлөө зөвлөлийн даргаар орон нутгийн хэмжээнд эрх зүйн акт гаргуулан биелэлтийг хангах, зөвшөөрөгдсөн хугацаанд зохион байгуулагдаж байгаа уралдааны үеэр хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажиллахад хяналт тавих | - | Орон нутагт гаргасан эрх зүйн актын тоо<br>Хяналт тавьж ажилласан уралдааны тоо, Уралдаанч хүүхдийн тоо, Хүүхдийн бэртэл гэмтлийн хувь, Цахим системд мэдээлэл оруулсан хугацаа | 2 | 5 | Хагас жилийн байдлаар нийт 3 удаагийн хяналтыг зохион байгуулж 150 гаруй уралдаанч хүүхдүүдийг эрсдэлээс хамгаалан бэртэл, гэмтэл гаргалгүй ажилласан байна. | |
| 6.5 | Гэр бүлийн хөгжлийг дэмжих сарын аяныг зохион байгуулах | 500.000 | Хэрэгжилтийн хувь | 0 | 100% | Гэр бүлийн хөгжлийг дэмжих сарыг 5 дугаар сарыг болгон хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн. Тус арга хэмжээний хүрээнд Засаг даргын санаачлагаар зорилтот 3 өрхөд 5 ханатай гэрийг олгосон. Мөн Нэг хамт олон нэг сайн дурын ажил аяны хүрээнд зорилтот нэг айлд ахуйн хэрэглээний тусламж, дэмжлэг үзүүлсэн. Гэр бүлийн өдрөөр “Аз жаргалтай гэр бүл” эвент арга хэмжээг зохион байгуулж, Гэр бүлийн харилцаа сургалт, | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөгжөөнт тоглоом зэрэг хөтөлбөрт ажлуудыг зохион байгууллаа. Нийт 50 гаруй иргэд, гэр бүлүүд оролцож уралдаанд 10 гэр бүл оролцож эхний 3 байрыг шалгаруулан шагнаж урамшуулсан. | |
| 6.6 | Сум, орон нутагт жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөг 2024-2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хяналт тавих | - | Хэрэгжилтийн хувь | 0 | 100% | Жендерийн эрх тэгш байдлыг хангах ажлын төлөвлөгөөнд 3 дугаар сарыг нэрэмжит сар болгон “Хайрлая хүндэлье” арга хэмжээг зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд Оюуны соронз сургалтын төвийн багш нарыг урьж “Хайрлдагдсан эмэгтэй”, “Эрчүүдийг ачаа нь чимдэг”, “Амжилт оргилд биш бэлд” сургалтууд зохион байгуулж 127 иргэд, 67 хүүхэд хамрагдсан. Мэдээллийн цагаар Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн сургалтыг 1 удаа зохион байгуулж 72 иргэн хамрагдсан. | 70% |
| 6.7 | Залуучуудын хөгжлийг дэмжих аргах хэмжээг зохион байгуулах | - | Хэрэгжилтийн хувь | 0 | 100% | III улирал улиралд хийхээр төлөвлөгөөг гарган ажиллаж байна | 30% |
| 6.8 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр ажлын байр нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлөөр хангах чиглэлээр зохион байгууллалтын арга хэмжээ авч ажиллах, ажилгүй иргэдийн судалгааг гаргах | - | Байнгын ажлын байраар хангагдсан иргэдийн тоо | 20 | 20 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тухай хуулийг танилцуулах сургалтыг 1 удаа зохион байгуулж 74 иргэн хамрагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг шинэчилэн гаргаж халамж үйлчилгээнд хамрагдалтын байдалд хяналт тавьж хөгжлийн брэхшээлтэй хүүхдээ асарч буй асран хамгаалагчийн нийгмийн даатгалыг төрөөс олгох үйлчилгээнд хамрагдах ёстой 6 асран хамгаалагчийг хамруулсан. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.9 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах арга хэмжээг зохион байгуулах | - | Хэрэгжилтийн хувь | 0 | 100% | Рашаан сувилалын хөнгөлөлт 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 276250₮, оршуулгын тэтгэмж 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 2000000₮ нийт 2276250₮ олгосон. Нийгмийн халамжийн тэтгэвэрт 23 хүнд 47327720₮<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асардаг асаргааны тэтгэмж 15 иргэнд 40956339₮ Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжинд 15 иргэнд 22172786₮ тус тус олгосон | |
| 6.10 | Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар авах арга хэмжээг зохион байгууллах | | Үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ сая төгрөгөөр | 0% | 100% | Ахмад настны протезийн хөнгөлөлт-6, оршуулгын тэтгэмж -1 ахмадад нийт 2600000 ₮, Насны хишиг 114 ахмад-9630000₮, нийгмийн халамжийн тэтгэвэр 3 ахмадад 5565000₮, ахмад настан асардаг асаргааны тэтгэмжинд 20 иргэнд 24619946₮, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжинд 20 иргэнд 940478₮ тус тус олгосон . | 100% |
| **7. Спорт үйл ажиллагаа, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх хүрээнд** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7.1 | Сум орон нутгийн иргэдийг эрүүлжих, чийрэгжихүүлэх нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх арга хэмжээг зохион байгуулах | - | Нийтийн биеийн тамирын спортоор хичээллэсэн иргэдийн тоо | 300 | 500 | "эртнээс сэрэмжлүүлэх тогтолцоонд учрах саад бэрхшээлийг хамтдаа шийдэцгээе зөвлөгөөний спортын арга хэмжээг 5 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд 2 өдрийн турш зохион байгуулагдаж, 19 сумын 104 төрийн албан хаагч оролцлоо. Малчид, төлчдийн зөвлөгөөний хүрээнд спортын тэмцээн уралдаан зохион байгуулж 110 малчид оролцсон. 6 сарын 1-нд хүүхэд багачуудын дунд олон төрөлт спортын арга хэмжээ зохион байгуулсан. Дугуй уралдаанд эрэгтэй 15 хүүхэд, эмэгтэй 10 хүүхэд оролцсон. Хөлбөмбөгийн тэмцээнд 76 хүүхэд оролцсон. Татвар төлөгчдийн өдрөөр сургуулийн сурагчдын дунд эрэгтэй, эмэгтэй волейбол, гар зургийн уралдаан зохион байгуулсан. Спортын арга хэмжээнд 138 сурагчид, 15 багш нар идэвхтэй оролцсон байна. Үүнээс эрэгтэй 75 хүүхэд, эмэгтэй 63 хүүхдүүд оролцсон. Сумын Засаг даргын тамгын газраас Ерөнхий боловсролын сургуулийн 5-9 дүгээр ангийн сурагчдын дунд ширээний теннисний тэмцээн зохион байгуулан ажиллалаа. Энэхүү тэмцээнд эрэгтэй 42 хүүхэд, эмэгтэй 30 хүүхэд оролцсон. | 100% |
| 7.2 | Сонгон дугуйлан хичээллүүлэх | - | Хамрагдарсан иргэдийг тоо | 0 | 2 | Волейбол, ширээний теннисны дугуйлан хичээллүүлж байна. 6-9 насны 25 хүүхэд, 10-14 насны 32 хүүхэд хамрагдаж байна. Мөн ширээний теннисны дугуйланд 25 хүүхэд хамрагдаж хичээллүүлж байна. | 70% |
| 7.3 | Аян зохион байгуулах | - | Хамрагдарсан | 0 | 3 | Ажлын байрны дасгалыг байгууллага болгон хийж хэвшсэн. Дасгалыг өглөөний 11 цагт | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | иргэдийг тоо | | | байгууллага дээрээ ажлын 5 өдөр хийдэг. Ажлын байрны дасгалд 120 албан хаагч хамрагдсан. Эрүүл Иргэн-Хонгорын баялаг 2025 групэд мэдээлэлээ оруулж , ирцээн бүртгүүлдэг. Цэцэрлэг, Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төвүүд хамрагдсан. | |
| **8.Санхүүгийн алба, төсөв, төрийн сангийн ажил үйлчилгээг хэрэгжүүлэх хүрээнд:** | | | | | | | |
| 8.1 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, санхүүгийн мэдээллийг олон нийтэд ил тод болгох | | Шилэн дансны цахим мэдээллийн нэмэгдүүлэлтийн хувь (Нягтлан бодогч нарын ажлын хариуцлагыг сайжруулах) | 30% | 100% | Шилэн дансны тухай хуулийн дагуу эхний хагас жилд ЗДТГ, ИТХ-ын мэдээллэх 146 мэдээллээс хугацаа хоцроон мэдээллэсэн – 4, хугацаандаа мэдээллэсэн – 142 ОНХС, Төсвийн ерөнхийлөн захирагчийн мэдээллэх 76 мэдээллээс хугацаа хоцроон мэдээллэсэн – 11, хугацаандаа мэдээллэсэн – 65 байна. | 70% |
| 8.2 | Хяналт шалгалт, дотоод аудитаар өгсөн зөвлөмж түүний хэрэгжилтийг хангах | Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилган ажиллах | Төлөвлөгөө боловсруулан биелэлтийг тухай бүр хянан ажиллаж зөрчилгүй байх | 30% | 100% | Хяналт шалгат болон дотоод аудитаар өгсөн зөвлөмж түүний хэрэгжилт бүрийг хугацаанд нь шийдвэрлэн зөрчлийг арилган ажилласан. Энэ оны эхний хагас жилд 2 удаа хяналт шалгалт ирсэн. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8.3 | Орон нутгийн хөрөнгөөр хэрэгжих худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж худалдан авах | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх | Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд tender.gov.mn-д байршуулж, ил тод байдлын хувь | 6 | 17 | Шинэжинст сумын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025.01.27-ны өдөр сумын Засаг даргаар батлуулан аймгийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. 2025.02 сард 2 төсөл арга хэмжээний, 3 сард 4 төсөл арга хэмжээний, 4 сард 4 төсөл арга хэмжээний, 5 сард 3 төсөл арга хэмжээний тендерүүдийг tender.gov.mn-ээр зарлаж, үр дүнг ил тод нийтэлсэн. | 50% |
| 8.4 | ажиллагааны төлөвлөгөө, тайланг цахим систем tender.gov.mn-ээр баталж, цахим системээр хуулийн хугацаанд ирүүлж ажиллана. | ажлуудыг төлөвлөгөөний дагуу цахим системээр зарлаж үр дүнг тухай бүр оруулах | | | | | |
| 8.5 | Төсвийн ерөнхийлөн захирагчид хамаарах байгууллагын ажилтнуудаас тухайн жилд шинээр 5 ажилтныг худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх | - | А3 сертификаттай ажилтны тоо | 2 | 5 | Худалдан авах ажиллагааны чиглэлээр одоогоор ажилчид, албан хаагчдыг хамруулаагүй байгаа. Шинэжинст сумын төрийн байгууллагуудын ЗДТГ-аас 3, ЕБС-с 4, Соёлын төвөөс 2 албан хаагч А3 сертификаттай. Худалдан авах ажиллагааны чиглэлээр албан хаагчид, иргэдийг мэргэшүүлэх ажлыг төлөвлөгөөндөө тусган батлуулсан. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8.6 | Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлагын мэдээллийн системийн бүрэн ашиглах, холбогдох мэдээллийг цаг тухайд нь оруулах | - | Гүйцэтгэлийн хувь (Удирдлага мэдээлэлийн систем болон Төрийн худалдан авах ажиллагааны сайтуудыг бүрэн ашиглах) | 30% | 100% | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй 5,7 тэрбумын төсөвт өртөгтэй 26 төсөл арга хэмжээнээс эхний хагас жилд 421 сая төгрөгийн 6 ажил бараа, үйлчилгээг бүрэн хэрэгжүүлэн мэдээллийг бүрэн оруулсан. Тендер зарлагдаагүй 1,1 тэрбумын 3 төсөл арга хэмжээ 17 төсөл арга хэмжээ нь 4,2 тэрбумын гэрээ байгуулан ажлаа эхлэн гүйцэтгэж байгаа. | 50% |
| 8.7 | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр эрх шилжүүлэн сумдад хийгдэж буй ажилд хяналт тавих, санхүүжилтийг нэхэмжлэхдээ гүйцэтгэлийг үндэслэн холбогдох материалын хамт санхүү төрийн санд ирүүлэх | - | Гүйцэтгэлийн хувь | 80% | 100% | Эрх шилжүүлэн хийгдэж буй төсөл арга хэмжээ байхгүй. | 0% |
| **9.Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, ашиг шимийг нэмэгдүүлэх, хүнс, худалдаа үйлчилгээний салбарын хүрээнд:** | | | | | | | |
| 9.1 | Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл, шаардагдах өвс тэжээлийн нөөцийг хангах | - | Бэлтгэл хангалтын хувь | 85% | 95% | Өвс тэжээлийн нөөцийг 05 дугаар сард аймгийн нөөцөөс ЭрдэнэМонгол ХХК-ийн дэмжлэгтэйгээр бүрдүүлэн ажилласан байна. | 50% |
| 9.2 | Мал сүрэгт үзлэг ангилалтыг технологит цаг хугацаанд хийж,бүртгэл мэдээллийн программд оруулах | - | Үзлэг ангилалт хийснээр | 500 | 1000 | Хаврын ангилалтаар 1 настай борлон ухны амьдын жингийн дундаж 20,8 кг, 2-3 настай өсвөр ухнын амьдын жингийн дундаж 31 кг,4 наснаас дээш настай бүдүүн ухнын амьдын жингийн дундаж 45,6 кг, 1 настай төлгөн хуцны амьдын жингийн дундаж 24 кг,2-3 настай өсвөр хуцны амьдын жин 36кг, 4 –өөс дээш настай бүдүүн хуцны амьдын жингийн дундаж 46,2 кг байв..Мөн богийн хээлтүүлэгчийг маллагч өрхүүдэд гарцыг хөтлөх гар картыг өгч хөтлүүлэн гарцыг тодорхойллоо.Ноолуурын | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гарцын дундаж 4500-6000 грамм байна.4-10 сар | |
| 9.3 | Шилмэл мал, бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа зохион байгуулах | - | Үзэсгэлэн худалдаа зохион байгуулснаар | 80% | 90% | 9 сард хийгдэхээр төлөвлөн ажиллаж байна. | 30% |
| 9.5 | Малын халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах | - | Төлөвлөгөөний биелэлтийн хувь | 85% | 100% | Хүлээгдэж байна. | 0% |
| 9.6 | Өвөлжөө, хаваржааны бууцны хөлд ногоон тэжээл тариалж тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх | - | Өрхийн тоо | 0 | 20 | Хаврын тариалалт хийгдэж дуусаагүй. Одоогоор өвөлжөө, хаваржааны бууцны хөлд тэжээлийн ургамал тариалсан өрх байхгүй. | 0% |
| 9.7 | Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх тариалалт ургац хураалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах (хавсралтаар) | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 90% | Төмс 1 га, манжин 0.21 га, хүрэн манжин 0.23 га, лууван 0.58 га, өргөст хэмх 0.13 га, лооль 1.09 га, халуун чинжүү 0.13 га, сонгино 0.39 га, сармис 0.01 га, газрын алим 0.75 га, амтат гуа 0.51 га, шийгуа 0.12 га, лидэр 0.03, гүргэм 0.03 га-д нийт 5.21 га талбайд 19 өрх 1 хоршоо тариалалт хийсэн. | 70% |
| 9.8 | Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийг сайжруулах чанаргүй зээлийн хэмжээг бууруулах, олгосон зээлийн мэдээллийг сар бүр шинэчилж олон нийтэд нээлттэй ил тод мэдээлэх | - | Чанаргүй зээлийн бууралтын хувь | - | 5% | Тухайн ажлын байр сул орон тоотой байгаа тул хүлээгдэж байна. | 0% |
| 9.9 | Хүнсний үйлдвэр цех, худалдаа хоол үйлдвэрлэл үйлчилгээний байгууллага, хүний нөөцийн судалгааг салбар тус бүрээр шинэчилж гарган ирүүлэх | - | Судалгааны тоо | - | 1 | Тухайн ажлын байр сул орон тоотой байгаа тул хүлээгдэж байна. | 0% |
| **10.Байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд:** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10.1 | Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх (хавсралтаар) | | Тарсан модны тоо | | Гэрээний зургаа дугаар хавсралтын хүрэх түвшний үзүүлэлтээр | Байгаль орчны зардлаас 18450000 төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр ногоон байгууламжид 52 сая төгрөг, орчны тохижилтод 320 сая төгрөг зарцуулахаар төсөв батлагдсан, тендер зарлагдан хэрэгжүүлэх шатандаа байна. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр ЭрдэнэМонгол ХХК 2024 онд 5 иргэн, 2025 онд 5 иргэнтэй гэрээ байгуулан урамшуулан ажиллаж байна. Мөн "Амралтаараа ажиллая" оюутан хөтөлбөр хэрэгжүүлж 20 оюутан хамрагдаж байна. Ногоон байгууламж дээр дадлагажин, ажиллаж урамшуулал хүртэж байна. Нийт 20 хүн ногоон байгууламжийн чиглэлээр урамшууллын байдалд хамрагдсан байна. Сумын хэмжээнд 2025 оны хагас жилд 145000 ширхэг мод газрын хөрсөнд суулган таригдсан дүн мэдээтэй байна. | 80% |
| 10.2 | Сумын ан агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах (Өлзийт, Галуут, Жаргалант, Бөмбөгөр, Бууцагаан, Баянбулаг, Шинэжинст, Баянцагаан, Бууцагаан, Баацагаан, Богд, Жинст) | | Хэрэгжилтийн хувь | - | 100% | Тус сумын агнуурын бүс нутагт 2 тэх агнуулах хүсэлтийг Байгаль орчны газарт тухайн хугацаанд нь хүргүүлсэн. Тэх агнуулах хугацаа болоогүй учир агнуурын үйл ажиллагаа явагдаагүй. 2025 оны эхний хагас жилд “Агьт” ангийн бүс нутагт 1 дүгээр сард 20 боодол өвс, 100 кг хужир, 05 дугаар сард 60 боодол өвс, 200 кг хужир тавьж өгөх ажлыг Засаг даргын Тамгын газраас холбогдох албан хаагчид малчны бүлгүүдтэй хамтран гүйцэтгэлээ. | Байгаль орчин |
| 10.3 | Зэрлэг ан амьдад зориулсан биотехникийн арга хэмжээ авах | | Зохион байгуулсан биотехникийн арга хэмжээний тоо | 2 | 2 | Зэрлэг ан амьдад зориулсан биотехникийн арга хэмжээ авах ажлыг 2025 онд 2 удаагийн байдлаар 5-6 цэгт авч ажилласан байна. ЭрдэнэМонгол ХХК-аас 100 боодол, ЗДТГ-аас 160 боодол өвс, 500 кг хужир бэлтгэн биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээр санхүүжих орлогоос 7 сая төгрөг биотехникийн арга хэмжээнд төлөвлөн санхүүг батлуулсан бөгөөд 5 сая төгрөгийн | Байгаль орчин |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажил үйлчилгээг биотехникийн арга хэмжээнд зарцуулж, өвлийн улиралд буюу шаардлагатай цаг үед биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр нөөц санхүү хөрөнгийг бэлдсэн байна. Байгаль орчны газраас ирүүлсэн 38 шуудай хорголжинг Цагаан богд орчмын 8 цэгт тавьж өгөх ажлыг хэрэгжүүлсэн. | |
| 10.4 | Мазаалай баавгайг хамгаалах чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | 1 | Мазаалай баавгайг хамгаалах зорилгоор жил бүрийн 2 дугаар сард үндэсний бахархалт амьтан, 3 дугаар сарын 15-ныг Баянхонгор аймгийн бахархалт амьтнаар өргөмжилсөн тул тэмдэглэлт өдрийг удирдамжийн дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн БОГ Мазаалайн тэжээл 38 уут хорголжинг гаргаж, гэрэл зурагчдын холбоотой хамтран сумын БОХУБ, Байгаль хамгаалагчдын хамт 10 цэгт тавьж өгөх ажлыг амжилттай гүйцэтгэлээ. Олон нийтэд сурталчлах зорилгоор “Мазаалайд манайд бий” уриатайгаар ахмадуудын дунд софт волейболын тэмцээн зохион байгуулан сурталчилж ажилласан бөгөөд нийт 56 хүн хамрагдсан байна. | Байгаль орчин |
| 10.5 | Гэр хорооллын нүхэн жорлонг бууруулж стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлэх | | Шинээр стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болсон айл өрхийн тоо | | Гэрээний зургаадугаар хавсралтын хүрэх түвшингээр | Нүхэн жоронг бууруулах чиглэлээр “Цэвэр орчин бүрдүүлэх тухай” ажлын төлөвлөгөөг сумын Засаг даргын захирамжаар батлуулан энэ 6 дугаар сард хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөгдсөн байна. Энэ ажлын хүрээнд гудамд байгаа нүхэн жорлонгуудыг буулгах, стандартын жорлонгийн тоог нэмэгдүүлэх боломжтой байна. | Байгаль орчин |
| 10.6 | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, эдийн засгийн эргэлтэд оруулах (хавсралтаар) | | Ангилан ялгаж тээвэрлэсэн | | Гэрээний зургаадугаар хавсралтын хүрэх | 03 дугаар улирлаас хийгдэхээр төлөвлөн ажиллаж байна | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | түвшингээр | | |
| 10.7 | Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2-т заасан журмуудыг сумын ИТХ-аар батлуулж, захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлэх | | Захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлсэн журмын тоо | 0 | 2 | Хог хаягдлын тухай хуулийн хүрээнд 2025 онд шинэчлэхээр "Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг шинэчлэн тогтоох тухай тогтоолыг сумын ИТХ-аар батлуулж, захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлэхээр хүргүүлэн ажиллаж байна. | Байгаль орчин |
| 10.8 | Байгаль орчноо хайрлан хамгаалах, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор иргэдэд экологийн боловсрол олгох сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах | | Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан иргэдийн тоо | - | 10 1000 | Удирдамжид заасны дагуу худалдаа үйлчилгээ эрхэлдэг иргэн аж ахуйн нэгж байгууллагын хүмүүсийг хамруулан "Усаа хэмнэе" уриатай волейболын тэмцээн, "Мазаалай манайд" уриатай софт, Ус бол эрдэнэ" уриатай буухиа тэмцээн зохион байгууллаа. Оройн арга хэмжээн дээр "Ус бол..." гэдэг дээр буухианд хүмүүсийн бичсэн сэтгэгдлийг тайлах, устай холбоотой хэлэлцүүлэг, сургалт нөлөөллийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Уртын гол багийн Иргэдийн Нийтийн хуралд очиж 156 иргэнд Байгаль орчныг хамгаалах, мод тарих, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, ус зэрэг сэдвээр мэдээлэл, нөлөөллийн ажил үүрэг гүйцэтгэсэн. | Байгаль орчин |
| 10.9 | Хүн амын унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрүүдийг улирал тутам шинжилгээнд хамруулах | | Шинжилгээнд хамруулсан давтамжийн тоо | 1 | 4 | Энэ оны эхний улирлын шинжилгээг өмнөх оны сүүлээр хамруулсан тул хийгдээгүй, 4 дүгээр сард 2 цэгээс дээж явуулсан байна. | Байгаль орчин |
| 10.10 | Гол мөрний дагуух ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг улирал тутам цэвэрлэх ажлыг зохион байгуулах | | Цэвэрлэгээний давтамжийн тоо | 2 | 4 | Усны эх үүсвэрийн хог хаягдлыг цэвэрлүүлэх ажил 2 удаа хийгдсэн. Сумын төвийг орчимд байрших Задгайн булгийн эхийг Сэкер ресорсус Монголиа ХХК, Цагаан хаалгын эхийг ЭрдэнэМонгол ХХК хариуцан сар бүр цэвэрлэн тайлан мэдээг ирүүлж хэвшсэн. Нийт 2 булгийн эхийг тус бүр 6 удаа цэвэрлэж 2,5 тн хог хаягдал | Байгаль орчин |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хогийн цэгт хүргэж ажиллав. | |
| 10.11 | Усны сан бүхий газар, Ус хангамжийн эх үүсвэрүүдийн хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх | | Тэмдэгжүүлсэн хамгаалалтын бүсийн тоо | - | 2 | Усны эх үүсвэрүүдийн эхийг хамгаалах зорилгоор Эрдэнэ Монгол ХХК-ны 4 уст цэгт хамгаалалтын бүс тогтоох тухай тогтоолыг гаргуулж ажиллалаа. Бүсийн тэмдэгжүүлэлт хийгдсэн. | Байгаль орчин |
| 10.12 | Хамгаалах шаардлагатай булаг шандын эхийг станпартын дагуу хашиж хамгаалах | | Хамгаалсан булгийн тоо | - | 1 | Цахилдагтайн булгийн эхийг М Си Эс Интернейшнл ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд хашиж хамгаалсан. Цагаан булгийн эхийг Сэкер ресорсус Монголиа ХХК хамгаалах санал солилцож, зөвшилцлөө. | Байгаль орчин |
| **11.Газрын харилцаа, дэд бүтцийн хүрээнд:** | | | | | | | |
| 11.1 | Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, сумын төвийн шинэчлэл хийлгэх зураг төсөвтэй болох | | Зураг төсөв | 1 | 1 | Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлыг даалгаврыг мэргэжилтэнгээс авч Засаг даргад танилцуулан, тендер зарлуулахаар ажлын хэсэг хүлээлгэн өгсөн. Тендер зарлагдаж 2025 оны 06 дугаар сарын 24 нд нээхээр байна. | 30% |
| 11.8 | Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийлгэх | | Хянан батлагаа хийлгэсэн тоо | 1 | 1 | Хот тосгон бусад суурин газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажил гүйцэтгүүлэхээр Экситос ХХК-тай 2025 оны 06 дугаар сарын 03 өдөр Засаг даргатай гэрээ байгуулсан. | 30% |
| 11.9 | Жишиг гудамж хашаа –тохижилтийн ажлыг зохион байгуулах | | Хашааны тоо | +500 | +500 | Жишиг гудамж хашаа тохижилтийн ажлыг даалгаврыг зургийн компаниар хийлгэж тендер зарлуулахаар ажлын хэсэг хүлээлгэн өгсөн. Тендер зарлагдаж 2025 оны 06 дугаар сарын 24 нд нээхээр байна. | 30% |
| **12.Батлан хамгаалах салбарын бодлого, үйл ажиллагаа, хууль тогтоомжийг сурталчлах, биелэлтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих бодлогын хүрээнд:** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12.1 | Батлан хамгаалах үйл ажиллагаа, бодлого, хууль тогтоомжийг сурталчлах, биелэлтийг хангах, цэргийн тоо бүртгэлийг зохион байгуулах | - | Цэргийн насны залуучуудад зохион байгуулсан арга хэмжээний тоо, бүртгэлд хамрагдсан иргэдийн тоо | 80% | 100% | Цэрэг таталгын 1, 2 дугаар ээлжийн цэрэг таталгаар Цэргийн насны давхардсан тоогоор 50 гаруй залуучуудад хууль тогтоомжийг сурталчан хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | 100% |
| 12.2 | Цэрэг татлагын ажлыг зохион байгуулж хяналтын тоог биелүүлэх | - | Цэрэг татлагын тоо<br>18-25 насны иргэдийг хамрагдалтын хувь | 2 | 2 | Хагас жилийн байдлаар 1 дүгээр ээлжийн цэрэг таталгыг 04 дүгээр сард зохион байгуулж 20 гаруй залуусаас 2 иргэнийг цэргийн албанд морьдуулан ажилласан байна. | 50% |
| 12.3 | Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлөх иргэдийн төлбөрийг төрийн санд төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах | - | Иргэдийн тоо | - | | Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийг төвлөрүүлэн ажилласан байна. | 50% |